



ОЛОН УЛСАД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН МАНДАХ ИХ СУРГУУЛЬ

NEWSLETTER

**2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлт
2019 оны 9 сарын 02-ны өдөр боллоо.**


Хичээлийн шинэ жилийг нээж сургуулийн захирал профессор Г.Нанжид үг хэллээ. Тэрээр хэлэхдээ “Манай хамт олон өнгөрсөн хичээлийн жилд өмнөө тавьсан зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд хэд хэдэн хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн, чанарын удирдлагын олон улсын стандарт хэрэгжүүлснээ баталгаажуулсан зэрэг багш, ажилтан, оюутан суралцагчид маань дор бүрнээ бахдам сайхан амжилт олсон жил боллоо. Бид бүхний алсын хараа-Судалгаанд суурилсан их сургууль болох зорилтын хүрээнд “МАНДАХ-2019” Олон улсын эрдэм шинжилгээний IV хурлыг амжилттай зохион байгууллаа. Оюутнууд маань их дээд сургуулиудын дунд зохион байгуулсан улсын олимпиад, эрдэм шинжилгээний хуралд эхний байр эзэлсэн зэрэг олон олон амжилтаар дүүрэн он жил байлаа хэмээн дурдсан.

Нээлтийн ёслолын үйл ажиллагааны үеэр Мандах их сургуулийн "Шинэ элсэгчдийг дэмжих тэтгэлэг" болон "Сурлагын амжилтаар олгох тэтгэлэг"-ийн болзлыг хангасан оюутнуудад 2019-2020 оны хичээлийн жилийн I улиралд сургалтын төлбөрийн 10-50%-ийн хөнгөлттэй суралцах эрхийн бичгийг гардууллаа.



**Эрдэм шинжилгээний
“Мандах эрдэм”
сэтгүүлийн анхны
дугаар хэвлэгдэн гарлаа.**

“Мандах эрдэм” сэтгүүлийн анхны дугаарт эдийн засаг, хүмүүнлэг, боловсрол, инженер, мэдээлэл технологийн чиглэлээр бичигдсэн 11 өгүүлэл англи, монгол хэл дээр нийтлэгдсэн байна.



Үйл явдлууд

ОЮУТНЫ КЛУБЫН ӨДӨРЛӨГ зохион байгуулагдлаа

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг уг үйл ажиллагааг 2019 оны 09 сарын 27-ны өдөр сургуулийн 3 давхрын В блокын задгай талбайд 15:00 цагт зохион байгуулав. Клуб сурталчлах өдөрлөгт доорх клубууд оролцлоо. Үүнд:

Судлаач оюутан клуб
НББ-ын сайн дурын клуб
Math lab клуб
IELTS training клуб
Plus клуб
ЕЕ клуб
Парламент мэтгэлцээний клуб
Super student мэтгэлцээний клуб
Reading клуб
Дууны клуб
Бүжгийн клуб
Сагсны клуб
Иогийн клуб

Тус хичээлийн жилд оюутны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, идэвх санаачилгыг нэмэгдүүлэхэд нь анхаарч “Клубын үйл ажиллагааг дэмжих журам” батлагдсан нь оюутнуудын идэвх сэргэж, өөрсдийн санаачилгаар клуб дугуйлан үүсгэн байгуулж, түүндээ бусад оюутнуудыг татан оролцуулж, үр нөлөө үзүүлж байгаа нь шинээр нээгдсэн клубүүдээс харагдаж байна. 2019-2020 оны хичээлийн жилд оюутан өөрөө санаачилсан болон багшаар удирдуулсан Парламент мэтгэлцээн, Иог, Нийгмийн хариуцлагатай оюутан, Plus, ЕЕ, Math Lab, Ielts training гэсэн клубууд шинээр нэмэгдсэн онцлогтой байлаа. Клуб тус бүр өөрсдийн үйл ажиллагааг танилцуулж, шинэ элсэгчдээ бүртгэн авлаа.



Үйл явдлууд

Дэлхийн багш нарын болон Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан шилдэг багш нараа шагнаж урамшууллаа

Дэлхийн багш нарын 25 жил, Монголын багш нарын 53 дахь удаагийн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан тус сургууль 2018-2019 оны хичээлийн жилд амжилт гаргасан шилдэг багш нараа уламжлалт ёсоор шалгаруулан шагнаж урамшууллаа. Үүнд:

“Оны шилдэг багш”-аар: Гадаад хэлний тэнхимийн ахлах багш Э.Оюун-Эрдэнэ

“Шилдэг залуу багш”-аар: Гадаад хэлний тэнхимийн багш С.Намуун нар шалгарч, Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

Үүний зэрэгцээ төр засгийн болон төрийн бус байгууллагын шагналаар дараах багш, ажилтнууд шагнагдав. Үүнд:

Ерөнхийлөгчийн зарлигаар **“Алтан гадас одон”**-оор Ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнээ,

Үндэсний статистикийн хорооны **“Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан”** цол тэмдгээр Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч, ахлах багш Н. Далайсайхан,

БСШУСЯ-ны **“Жуух бичиг”**-ээр: Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш, доктор А. Наранцэцэг, багш Ц.Одгарав,

Монголын Залуучуудын Холбооны **“Хөдөлмөрийн алдар”** алтан медалиар НББ-ийн тэнхимийн ахлах багш М. Энхсүрэн, **“Шилдэг залуу багш”** алтан медалиар ГХТ-ийн багш Ш.Нандинцэцэг, ЭЗБТ-ийн багш Ж. Гантулга,

Монголын улаан загалмайн нийгэмлэгийн **“80 жилийн ойн медаль”**-иар НББ-ийн тэнхимийн багш Г.Хандсүрэн, Захиргааны ахлах багш Б. Мөнхтуяа нар,


Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн ЭЗБТ-ийн эрхлэгч доктор, дэд профессор С.Цолмон, багш Ж. Гантулга нар Мандах их сургуулийн **“Онцгой амжилтын шагнал”**-аар тус тус шагнагдлаа.



Үйл явдлууд

Мод тарьж, амьд өв үлдээе

Мандах их сургуулийн Санхүү, хангамж үйлчилгээний албанаас санаачлан, 2020 онд төгсөх оюутнуудын дэмжлэгтэйгээр “Мод тарьж, амьд өв үлдээе” уриан дор 2019 оны 9-р сарын 26-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 200 ш мод суулгаж, “Мандах төгөл”-ийг байгууллаа. “Мандах төгөл” нь жил бүрийн намар өргөжин тэлнэ. Хүн, ургамал, ан амьтан, ус, агаар бичил биетэн гээд байгалийн бүх баялаг ой модноос хамааралтай. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулахад ой мод хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг учир бид бүхэн энэхүү арга хэмжээг уламжлал болгон хийхээр санаачилсан юм.



Үйл явдлууд

Авьяаслаг Мандахчууд

Мандах их сургуулийн 1-р курсын оюутнуудын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Оюутны урлагийн наадам” 2019 оны 10 сарын 05-ны өдөр Төмөр замын соёлын ордонд амжилттай болж өндөрлөлөө.

Урлагийн наадамд долоон хөтөлбөрийн оюутнууд оролцож, авьяасаа сорьсноос:

I байрт 85 оноогоор Нягтлан бодох бүртгэл– Аудит 1-р дамжаа

I байрт 76,5 оноогоор Нягтлан бодох бүртгэл - Банк 1-р дамжаа

III байрт 65,5 оноогоор Инженер эдийн засаг, Логистик менежмент 1-р дамжааны хамт олон тус тус шалгарлаа.

Шилдэг FLASH MOB–р НББ-Англи хэл 1-р дамжааны оюутнуудын бүжиг шалгарч, сургуулийн “Оюутны шинэ жилийн баярын цэнгүүн”-д бүжиглэх урилгыг гардан авлаа.

Шүүгчдийн бүрэлдэхүүнд Монголын Төмөр замын чуулгын гоцлол дуучин МУСТА Бадамсүрэн, гоцлол бүжигчин МУСТА Отгонзул, Захиргааны менежер Мөнхцэцэг, Захиргааны ахлах ажилтан Мөнхтуяа нар оролцож ажиллав. Энэ хичээлийн жилийн оюутны урлагийн наадмын онцлог нь монгол бүжгийн үзүүлбэрүүд хамтлаг болон өргөжиж, анги хамт олны идэвх оролцоо нэмэгдсэн байлаа.



Үйл явдлууд

Мандах их сургуулийн номын сангийн санаачилгаар Номын сан сурталчилах 7 хоног” аяныг амжилттай зохион байгууллаа

Мандах их сургуулийн номын сангийн санаачилгаар “Номын сан сурталчлах 7 хоног” аяныг амжилттай зохион байгууллаа. Тус сургуулийн номын санг сурталчлах 7 хоногийн аян 2019 оны 11-сарын 4-нөөс 8-ны өдрүүдэд “Ёс зүй”-н сэдвийн хүрээнд зохион байгуулагдлаа. Дараах үйл ажиллагааг хөтөлбөрийн дагуу зохион явуулав.

Үүнд: Электрон каталоги ашиглах, цахим ном унших, шинэ номын тухай мэдээ, мэдээлэл харах, номын сангийн мэдээллийг <http://mandakh.edu.mn/> сургуулийн сайтаас ашиглах талаар мэдээлэл хийлээ. “УХААЛАГ МОНГОЛ ХҮҮХЭД”-Уншлагыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж “Бага насны хүүхдийн ном хандивлах аян”-ыг зохион байгуулж, нийт 30 багш, ажилчдаас 130 гаруй ном цугларснаар багш, ажилчдын хүүхдэд гэрээр ном олгох үйлчилгээг зохион байгууллаа. Харилцаа, Ёс зүй, Хувь хүний хөгжлийн номоор сэдэвчилсэн үзэсгэлэнг Номын сангийн уншлагын заал болон 3 давхрын оюутны чөлөөт зааланд гаргаж, оюутнуудад танилцуулав. Оюутнуудын дунд сургуулийн дүрэм журам, түүх, соёл, уран зохиол, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд 36 оюутан 18 багт хуваагдан оролцож авхаалж самбаа, оюун ухаанаа сорилоо. Тэргүүн байранд НББ-Банк 3-р дамжааны оюутан Д. Тэгшзаяа, НББ-Банк 3-р дамжааны оюутан Б.Алтанцэцэг нар шалгарлаа. СШУИТ-ийн багш Доктор (Ph.D), профессор Ж.Чимгээгийн “Харизмын үнэ цэнэ” өөрийгөө өөрчилж, амжилтаа ахиулах талаар сонирхолтой лекц боллоо. Уг лекцэд 1-р курсын 200 гаруй оюутнууд оролцов. Номын сан СШУИТ-тэй хамтран Доктор (Ph.D), ахлах багш Н.Сэлэнгээгийн “Бизнесийн ёс зүй” хичээлийн хүрээнд “Podcast” сонссон номоороо НББ-ийн 3-р дамжааны оюутнуудын хийсэн номын хэлэлцүүлэг амжилттай явагдлаа. Оюутнууд баг болж хэлэлцүүлэгт бэлдсэнээр бусдын өмнө чөлөөтэй ярьж сурах, өөртөө итгэлтэй болох, уншсан номоо сонирхолтой байдлаар товч тэмдэглэл хийх зэрэг ач холбогдолтой юм. Хэлэлцүүлэгт 3 багийн 9 оюутан оролцлоо.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургууль, ОХУ-ын Тувагийн Бүгд Найрамдах Улсын Кызыл хотын Хэлний сургалтын “Эрдэм” төвтэй хамтран ажиллах тухай гэрээ байгууллаа

Мандах их сургууль, Хэлний сургалтын “Эрдэм” төвийн хооронд хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа 2019 оны 9-р сарын 2-ны өдөр Мандах их сургуулийн хурлын танхимд болов.

Ёслолын ажиллагаанд Мандах их сургуулийн захирал, профессор Г. Нанжид тэргүүтэй Мандах их сургуулийн удирдлага болон ОХУ-ын Тува улсын Кызыл хотын Хэлний сургалтын “Эрдэм” төвийн удирдлага оролцлоо. Гэрээнд Мандах их сургуулийг төлөөлөн сургалт эрхэлсэн дэд захирал доктор, дэд профессор Ч. Төрбадрах, Хэлний сургалтын “Эрдэм” төвийг төлөөлөн захирал Донгак Буян Мэргэн-Оолович нар гарын үсэг зурав.

Хамтран ажиллах гэрээнд Кызыл хотын хэлний сургалтын төвийн монгол хэлний бэлтгэл ангид суралцаж, шалгалтаа амжилттай өгсөн, элсэлтийн шалгуур шаардлагыг хангасан суралцагсдыг тэдний хүсэлтийн дагуу Мандах их сургуульд элсүүлэн суралцуулах, сургалтын арга зүйн туршлага солилцох чиглэлээр хамтран ажиллах чиглэлүүд тусгагдсан болно



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургууль Австрали улсын South Cross их сургуультай хамтран ажиллах

Мандах их сургууль Австрали улсын South Cross их сургуультай сургалтын болон эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр байгуулав. Энэхүү санамж бичгийн хүрээнд хоёр сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, багш, оюутнуудын мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэгдсэн богино болон урт хугацааны суралцах аялал зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.



Гадаад хамтын ажиллагаа

Мандах их сургууль БНСУ-ын Хандонг их сургуультай хамтран ажиллах тухай гэрээ байгууллаа

Мандах их сургууль байгууллагынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэн, боловсрол, эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, дээд боловсролыг олон улсын чанартай болгох, хоёр орны соёлын харилцааг бэхжүүлэх зорилгын хүрээнд хамтран ажиллахаар БНСУ-ын Хандонг их сургуультай харилцан тохиролцож, хамтран ажиллах тухай гэрээ 2019 оны 7 дугаар сарын 4-нд байгуулав. Хамтран ажиллах гэрээний хүрээнд багш, ажилтан, оюутан солилцооны хөтөлбөрийг эхний ээлжинд авч хэрэгжүүлэхээр хоёр тал тохиролцлоо. Солилцооны хөтөлбөрийн хүрээнд хоёр сургууль эрдэмтэн багш нарын хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхүүлэн дэмжих, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад хамтран ажиллах, мэдлэг мэдээлэл, туршлагаа хуваалцах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах юм. Оюутан солилцооны хөтөлбөрийн хувьд хичээлийн жилийн улирал бүрд хоёр хүртэлх оюутан тус хоёр сургуульд харилцан суралцах бөгөөд Мандах их сургуулийн оюутнуудад өндөр хөгжилтэй оронд суралцаж, шинэ мэдлэг, ур чадварыг эзэмших таатай боломж бий болж байгаа юм.



Үйл явдлууд

Мандах их сургуулийг үүсгэн байгуулагч Б.Сандагсүрэнгийн нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа

Мандах Их Сургуулийн үүсгэн байгуулагч Б. Сандагсүрэнгийн нэрэмжит сургуулийн аварга шалгаруулах уламжлалт спорт тэмцээн 2019 оны 10 сарын 29-ны өдрөөс 11 сарын 10-ны өдрийг хүртэл амжилттай болж өндөрлөлөө.

Сургуулийн аварга шалгаруулах энэхүү тэмцээнийг 1997 оноос уламжлал болгон зохион байгуулж ирсэн бөгөөд сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар гэсэн 4 төрөлт тэмцээн болон өргөжиж, тамирчдын чансаа ч улам сайжирч байна.



Тэмцээнд нийт 32 баг тамирчид хоёр долоо хоногийн турш өрсөлдөж өнөөдөр нэгдсэн дүнгээ гаргаж, аваргуудаа тодрууллаа. Үүнд:

Сагсан бөмбөгийн төрөлд:

Эрэгтэй баг:

I байрт- Програм хангамж-3

II байрт- Санхүү банк-3

III байрт- Програм хангамж-2

Шилдэг тоглогч: Нямдаваа / Програм хангамж-3/

Эмэгтэй баг:

I байрт- НББ- Татвар-3

II байрт- НББ-Татвар-2

III байрт- НББ- Татвар-1

Шилдэг тоглогч: Лхагважаргал /НББ-Татвар-3/

Ширээний теннисийн төрөлд:

Эрэгтэй:

I байрт: Х.Балжинням /НББ-Аудит-4/

II байрт Ч. Өсөхбаяр /НББ-Татвар-3/

III байрт: Б.Хишигжаргал /НББ-МС-3/

Эмэгтэй:

I байрт: Нандинцэцэг /Санхүү банк-4/

II байрт: Х.Золжаргал /НББ-Банк-4/

III байрт: Б.Баянжаргал /НББ-статистик-2/

Шатрын төрөлд:

Эрэгтэй:

I байрт: М.Хүслэн /НББ-МС-4/

II байрт: : М.Мөнхбат /НББ-Аудит-3/

III байрт: : Г.Ган-Эрдэнэ /ПХ-2/

Эмэгтэй:

I байрт: А.Үүрцолмон/НББ-АХ-2/

II байрт: Х.Золжаргал /НББ-Банк-4/

III байрт: А.Буяндэлгэр /НББ-статистик-2/

Уралдаан тэмцээн

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн авхаалж сорих тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа

Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимээс гуравдугаар курсын оюутнуудын дунд НББ-ийн мэргэжлийн Авхаалж сорих тэмцээнийг /АСТ/ жил бүр зохион байгуулдаг уламжлалтай билээ.

НББ-ийн АСТ-ний эхний шат 2019 оны 11 дүгээр сарын 28-нд Мандах их сургуулийн хичээлийн байранд эхэлсэн бөгөөд 11 дүгээр сарын 29-нд Төмөр замын дуу бүжгийн чуулгын байранд эцсийн шалгаруулалт явагдан, дүнгээ гаргалаа.

НББ-ийн АСТ-нд гуравдугаар курсийн нийт 6 анги оролцсоноос:

Нэгдүгээр байр- НББ-Аудит-3 ангийн “Мандах нар” баг, 39.51 оноогоор,



Уралдаан тэмцээн

Менежментийн улсын XIII олимпиадад Мандах их сургуулийн Дархан салбар сургууль хувийн дүнгээр алтан медаль, багийн дүнгээр мөнгөн медаль хүртлээ

ХААИС-ийн ЭЗБС-ийн Менежментийн тэнхим, Монголын Менежментийн холбоо, “Жандагсүрэн сан”-тай хамтран эдийн засаг, менежментийн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургууль, коллежуудын оюутнуудын дунд Менежментийн улсын XIII олимпиадыг 2019 оны 12-р сарын 12, 13- ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж дүнгээ гаргалаа. Энэ жил дотоодын 9 их, дээд сургуулийн 13 багийн нийт 65 оюутан оролцож, онолын мэдлэг, чадвараараа өрсөлдөн Мандах их сургуулийн Дархан салбар сургуулийн оюутнууд хувийн дүнгээр тэргүүн байр болон гуравдугаар байр, тусгай байруудыг эзэллээ. Мөн багийн дүнгээр мөнгөн медалийн эзэд боллоо.

ОЮУТНУУД ХУВИЙН ДҮНГЭЭР:

1. **Б.Нямжаргал Дархан-Мандах ИС I**
2. Г.Ууганбаяр ШУТИС- БУХС II
3. Б.Бэгз ШУТИС- БУХС II
4. **Я.Мядаг Дархан-Мандах ИС III**
5. З.Үлэмжзаяа МУИС- БС III
6. Ө.Аминаа ОУЭЗБДС- Тусгай байр
7. Г.Дэчмаа ШУТИС- БУХС Тусгай байр
8. **А.Ундармаа Дархан-Мандах ИС Тусгай байр**
9. Б.Батбаяр ШУТИС- БУХС Тусгай байр
10. **Н.Номин Дархан-Мандах ИС Тусгай байр**
11. Б.Болдбаяр ОУЭЗБДС Тусгай байр
12. Б.Батхишиг ХААИС- ЭЗБС Тусгай байр
13. Ө.Энхжин ОУЭЗБДС- Тусгай байр
14. О.Дөлгөөнмөрөн МУИС- БС Тусгай байр
15. Б.Гансүх ОУЭЗБДС- Тусгай байр

СУРГУУЛИУД БАГИЙН ДҮНГЭЭР:

Нэгдүгээр байр: Гранпри цом ШУТИС- БУХС

Хоёрдугаар байр: Дархан-Мандах ИС

Гуравдугаар байр: ОУЭЗБДС



Уралдаан тэмцээн

Монгол улсын их, дээд сургуулийн оюутнуудын шилдэг бүтээлийн уралдаанд Мандах их сургууль II, III байрт шалгарлаа

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил, даатгалын салбарын 85 жилийн ойд зориулан судлаачид, оюутнуудын дунд шилдэг бүтээлийн уралдаан зарлаж, нийт 32 бүтээл ирснээс 12 бүтээлийг шалгаруулсан. Сонгогдсон 12 бүтээлээс оюутан, судлаачийн ангилал тус бүрээс шилдэг 3 бүтээлийг шалгаруулах эрдэм шинжилгээний хурал амжилттай боллоо.

Хурлын үеэр СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн баяр хүргэн үг хэлж, шилдгүүдийн шагналыг гардуулав. Оролцогчдоос оюутны ангилалд тэргүүн байранд “Хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдалд “Miles-Ezzell болон Modigliani-Miller”-ийн засварлалтыг ашиглах нь” бүтээлээр МУИС-ийн оюутан Д.Ганбаяр, дэд байранд “Эх орны хишиг 1072 хувьцааг зохистой удирдах замаар хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж” бүтээлээр Мандах Их Сургуулийн оюутан Г.Бат-Эрдэнэ, Б.Нямтуяа нар, III байрт “Хувьцааны төвлөрөл болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлын шинжилгээ” бүтээлээр Мандах Их Сургуулийн оюутан Б.Алтанзул шалгарлаа.



Уралдаан тэмцээн

“Нээлттэй хаалганы өдөрлөг” боллоо

Мандах их сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөг 2019 оны 12 сарын 6-ны өдөр боллоо. Өдөрлөгийг уламжлал болгон 3 дахь жилдээ зохион байгуулж байна. Өдөрлөгт 1, 3, 5, 45 -р сургуулийн сурагчид ангийн багшийн хамт оролцлоо.

ЕБС-ийн сурагчдад сургуулийн түүхэн замнал, амжилт бүтээл, 2019-2020 оны хичээлийн жилд элсэлт авах хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл хүргэлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл, Банкны менежмент, Санхүүгийн менежмент, Инженер эдийн засаг, Програм хангамж, Мэдээллийн системийн хөтөлбөрөөс гадна шинээр нээгдсэн Логистик менежмент, Компьютерийн сүлжээ, График дизайн, Англи хэлний орчуулагч гэсэн хөтөлбөрүүдээ танилцуулж, ЭЕШ-даа бэлтгэх арга техник, цагийн менежментийг зөв ашиглах зөвлөгөө өглөө.

Мөн тус сургуульд элсэн ороод хамрагдах боломжтой шинэ элсэгчдийг дэмжих тэтгэлэг, Сурлагын амжилтыг дэмжих “Захирлын нэрэмжит тэтгэлэг” Онцгой амжилт гаргасан оюутанд олгох шагнал урамшуулал болон сургалтын төлбөрийн хөнгөлөлт, сургалтын зээл, буцалтгүй тусламжийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хүргэлээ.

Түүнчлэн чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлэх боломжтой дугуйлан, клубүүдийн тухай танилцуулан, бүжгийн дугуйлангийн оюутнууд дэглэсэн бүжгээрээ мэндчилгээ дэвшүүлээ.

Хүрэлцэн ирсэн сурагчдын дунд асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулж, гарын бэлэг гардууллаа.



Шагнал урамшуулал

Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгийг Мандах их сургуулийн 2 оюутан хүртлээ

Мэдлэг боловсрол, бүтээлч чанар, шинэ санаа, сайн үйлс, авьяас, ур чадвараараа онцгой амжилт гаргасан нэр бүхий 27 оюутан Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг хүртлээ. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх тэтгэлгийг гардуулан баяр хүргэж, цаашдын сурлага, хөдөлмөрт өндөр амжилтыг хүсэн ерөөв. Мөн эх орныхоо төлөө хүн бүр, ялангуяа ирээдүйг авч явах залуус хичээн зүтгэж, ажиллаж хөдөлмөрлөхийг уриаллаа.

Мандах их сургуулийн **Нягтлан бодох бүртгэл-Банк хөтөлбөрийн суралцагч О.Сарангуа, Нягтлан бодох бүртгэл-Аудит хөтөлбөрийн суралцагч С.Цэвээнжаргал** нар Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн нэрэмжит тэтгэлэг хүртлээ.

Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг дараах болзолд үндэслэн олгодог ба суралцагсад Монгол Улсын Ерөнхий сайдын өргөмжлөл, нэг сая төгрөгийн тэтгэлэг хүртдэг байна. Үүнд:

Монгол Улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр үр ашиг, ач холбогдол бүхий шинэ технологи, бүтээгдэхүүн, материал бий болгон үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх шинэ санаачилга гаргасан. Сайн санааны үндсэн дээр нийгмийн сайн сайхны тусын тулд бусдыгаа манлайлан идэвх зүтгэл гаргаж үлгэр жишээ болох ажил санаачлан зохион байгуулсан, эерэг өөрчлөлтөөр бусдадаа үлгэр дуурайлал болсон, Монгол хэл, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулан өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлсэн, Амжилттай суралцаж бусдад үлгэр дуурайлал болсон, улс орны хөгжилд эерэг үр нөлөө үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний бүтээл туурвисан, оновчтой үр дүнтэй бодлого төлөвлөгөө, зөв шийдэл, арга барил бүхий нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн төсөл, хөтөлбөр санаачилан бичиж хэрэгжүүлсэн байх шалгуурыг хангаснаас гадна “Монгол Улсын ирээдүйн хөгжил ба миний оролцоо” сэдэвт эссэ бичсэн зэрэг болно.



Шагнал урамшуулал

“АЛУНГОО-2019” БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ОНЫ ЭМЭГТЭЙГЭЭР ШАЛГАРЛАА

95 жилийн түүхтэй Монголын эмэгтэйчүүдийн холбооноос жил бүр салбар салбарын Шилдэг эмэгтэйчүүдийг шалгаруулан Алунгоо цом, өргөмжлөлийг гардуулдаг уламжлалтай.

Энэ оны “БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ОНЫ ЭМЭГТЭЙ”-гээр Мандах их сургуулийн захирал Гомбожавын Нанжид шалгарсан юм.

Г.Нанжид нь боловсролын салбарт 47 жил тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд 1992 онд Мандах их сургуулийг үүсгэн байгуулах үеэс өнөөг хүртэл удирдан ажиллаж байна.

Мандах их сургууль нь Монголын дээд боловсролын салбарт нэр хүндтэй шилдэг сургууль төдийгүй, олон улсад магадлан итгэмжлэгдсэн, Дэлхийн бизнесийн холбооны “2018 оны шилдэг байгууллага” өргөмжлөл хүртсэн бөгөөд Монголын дээд боловсролын салбарт Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлсэн анхдагч байгууллага төдийгүй дээд боловсролын чанарын удирдлагын ISO 21001:2018 олон улсын стандартыг анхлан нэвтрүүлэгч байгууллага болох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа юм.

Тэрээр залуусыг өв тэгш, хүмүүжил, ёс суртахуунтай, эх оронч үзэлтэй оюунлаг мэргэжилтэн болгоход чиглэгдсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа нь үр дүнгээ өгч, Монголын ажил олгогч эздийн холбооноос “Төгсөгчдийн ажлын байрны хангамж сайтай сургууль”-аар өргөмжилсөн байна.



Шагнал урамшуулал

Мандах их сургууль Оны шилдгүүдээ тодрууллаа

Мандах их сургуулийн Багш, оюутны шинэ жилийн баярын цэнгүүн 2019 оны 12 сарын 24-ны өдөр болж 2019 оны шилдгүүдээ тодрууллаа.

2019 оны **ТОП-10** оюутнаар:

1. Б.Анхзаяа /Дархан салбар сургууль/
 2. Г.Мөнхтүвшин /Нягтлан бодох бүртгэл-аудит 4 /
 3. Б.Нямтуяа / Нягтлан бодох бүртгэл- Аудит 4/
 4. С.Цэвээнжаргал /Нягтлан бодох бүртгэл- Аудит 4/
 5. О.Лхагва-Очир /Нягтлан бодох бүртгэл- Аудит 3/
 6. А.Цэвээндаш /Нягтлан бодох бүртгэл- Аудит 4/
 7. Б.Мандах-Энхжин /Дархан салбар сургууль/
 8. Б.Мөнхчимэг /Дархан салбар сургууль/
 9. М.Ундрал / Нягтлан бодох бүртгэл- Банк 3/
 10. Б.Оюунтунгалаг /Дархан салбар сургууль/
 11. Э.Энхдэлхий /Дархан салбар сургууль/
- Ч.Наранчимэг / Нягтлан бодох бүртгэл– Англи хэл 3/

Мандах их сургуулийн Бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутанд олгох шагнал ба тэтгэлэг журмын дагуу Оюутны зөвлөлд идэвх санаачлагатай ажилласан дараах оюутнуудад сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгосон байна.

1. Ч.Өсөхбаяр /НББ-Татвар 3/- Оюутны зөвлөлийн Дарга -10%
 2. Н.Сумьяабазар /НББ-Банк 4/- Оюутны зөвлөлийн Дэд Дарга- 10%
 3. А.Мөнхмарал /НББ-Статистик 3/- Оюутны зөвлөлийн Нарийн Бичиг- 5%
- Ү.Отгонзаяа /НББ-Банк 3/- Оюутны зөвлөлийн Хяналтын хорооны дарга- 5%

2019 оны ШИЛДЭГ АЖИЛТАН-аар Чанарын үнэлгээний мэргэжилтэн П.Болормаа, Магистрант, докторантын эрдэм шинжилгээний Шилдэг бүтээлд олгох тэтгэлэгийг Эдийн засаг, бизнесийн тэнхимийн багш Б.Сайнжаргал нар хүртлээ.

Багш нарын шинэ жилийн баярын цэнгүүний шилдэг мэндчилгээгээр Суурь шинжлэх ухаан, инженерчлэлийн тэнхимийн хамт олон тодорч, мөнгөн шагналын эзэд боллоо.

Жил бүр уламжлал болгон явуулдаг “Нягтлан бодох бүртгэлийн үндэс” хичээлийн олимпиадын эхний гурван байрт шалгарсан оюутнуудын шагналыг гардууллаа.

о 1-р байр Б.Дорждэрэм / Нягтлан бодох бүртгэл-Англи хэл 1/

о 2-р байр Т.Хонгорзул / Нягтлан бодох бүртгэл-Аудит 1/

о 3-р байр М.Номин-Эрдэнэ /Дархан-Уул салбар сургууль/



Шагнал урамшуулал

Салбарын Шилдэг залуу эрдэмтнээр Мандах их сургуулийн ЭЗБТ-ийн эрхлэгч, доктор, дэд профессор С. Цолмон шалгарлаа

Монголын Залуу эрдэмтдийн холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Шилдэг 100 Залуу Эрдэмтэн Судлаачдын шинэ жилийн цэнгүүн" 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдлаа. Цэнгүүний үеэр Монголын Залуу эрдэмтдийн холбооны 7 салбар холбоодоос Салбарын 2019 оны Шилдэг залуу эрдэмтдийг тодруулсан юм. Шилдэг залуу эрдэмтдээр:

- С.Тунгалаг, АШУҮИС-ийн Чанарын баталгаажилтын албаны Эрдэм шинжилгээний чанар хариуцсан арга зүйч, Токиогийн Шүдний их сургуулийн Клиникийн патофизиологийн тэнхмийн зочин багш, доктор /Анагаах ухааны салбар/
- Ө.Энэрэлт, МУИС, ШУС-ийн Биологийн тэнхмийн багш, доктор, дэд профессор /Байгалийн ухаан/
- С.Жавхлан, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан /ХАА-Биотехнологи/
- **С.Цолмон, Мандах их сургуулийн Эдийн засаг, бизнесийн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор /эдийн засаг, бизнесийн удирдлагын салбар/**
- Д.Даваадорж, МУИС, БУС-ийн Газарзүйн тэнхмийн багш, дэд профессор, доктор /Газарзүй, геологийн салбар/
- Л.Мөнхбаяр, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан /



Редакцийн зөвлөл:

Ч.Төрбадрах / Сургалт эрхэлсэн дэд захирал /
И-мэйл: turbadrakh@mandakh.edu.mn

С.Булганаа / Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан /
И-мэйл: foreignrelations@mandakh.edu.mn

Г.Энхжин /Номын санч/
И-мэйл: Enkhjin@mandakh.edu.mn